



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/33

Мандалговь

Гамшиг, онцгой байдлын үед ажиллах
хүүхэд хамгааллын мэргэжлийн
анги байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.8, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам”-ын 2.9.3 дахь заалтууд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/10 дугаар тушаалын 1, 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлд тусламж дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги”-ийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажлын чиг үүргийг 2 дугаар, төсвийг 3 дугаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн үйл ажиллагаанд зарцуулагдах 597800 (Таван зуун ерэн долоон мянга найман зуу) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

3. Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг онцгой байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлд тусламж дэмжлэг үзүүлэх журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг мэргэжлийн ангийн ахлагч (Б.Цэцэг), гишүүдэд үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн (Р.Мөнхбат)-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтийн үр дүнг 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулж, ажиллахыг хүүхэд хамгааллын мэргэжилтэн (Б.Цэцэг)-д даалгасугай.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/16 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

48119006

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны 04 дугаар сарын 2-ны өдрийн
А/33. дугаар тушаалын 21. дүгээр хавсралт



ГАМШИГ, ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕД АЖИЛЛАХ
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Мэргэжлийн ангийн дарга : Хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Гэр бүлийн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд: Хүүхэд хамгаалал, залуучуудын асуудал
хариуцсан мэргэжилтэн

Хамгаалах байрны арга зүйч, сэтгэлзүйч

Захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах
мэргэжилтэн

Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан
мэргэжилтэн

Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн
сан хариуцсан мэргэжилтэн

Архив, бичиг хэрэг, олон нийт хариуцсан
ажилтан

Залуучуудын хөгжлийн төвийн ажлын
албаны нарийн бичиг

Залуучуудын оролцоо, хамтын ажиллагаа
хариуцсан ажилтан

ЗХТ-ийн сургалт хариуцсан ажилтан


Хүүхдийн паркийн захирал

Нягтлан бодогч

Нярав

Жолооч

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны 04 дугаар сарын 12-ны өдрийн
А/33 дугаар тушаалын 02 дугаар хавсралт



ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГ

1. **Түргэвчилсэн үнэлгээ хийх багийн гүйцэтгэх үүрэг:** Гамшгийн дараа хүүхдийг хамгаалах хэрэгцээний талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх үйл явц юм. Мөн гамшигт үзүүлж буй нөлөөлөл, хүүхдэд үзүүлж буй үйлчилгээ, хэрэгцээг тодорхойлно.

Түргэвчилсэн үнэлгээ хийх багийн гишүүд:

- Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн
- Архив бичиг хэрэг, олон нийт хариуцсан ажилтан
- Нярав
- Жолооч

2. **Тусгаарлагдсан хүүхэдтэй ажиллах багийн гүйцэтгэх үүрэг:** Гамшиг онцгой байдлын үед хүүхэд эцэг эх, асран хамгаалагч, төрөл садангаасаа төөрөх, тусгаарлагдахаас урьдчилан сэргийлэх, тусгаарлагдсан хүүхдийг эрэн хайх, бүртгэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх, нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх.

Тусгаарлагдсан хүүхэдтэй ажиллах багийн гишүүд:

- Хүүхэд хамгаалал хариуцсан мэргэжилтэн
- Хүүхэд хамгаалал, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн
- Нягтлан

3. **Жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх багийн гүйцэтгэх үүрэг:** Жендэрээс үүдэлтэй хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, гэр бүлтэй ажиллах, гэр бүлийн орчинд хийсэн нөхцөл байдлын үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан зохих үйлчилгээнд холбон зуучлах

Жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх багийн гишүүд:

- Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Захиргаа, хүний нөөц, хариуцсан ахлах мэргэжилтэн
- Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн

4. **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багийн гүйцэтгэх үүрэг:** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд, нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багийн гишүүд:

- Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн
- Залуучуудын хөгжлийн төвийн ажлын албаны нарийн бичиг

5. **Нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх багийн гүйцэтгэх үүрэг:** Гамшгийн үед болон дараа нь нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх

Нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх багийн гишүүд:

- Хамгаалах байрны арга зүйч, сэтгэлзүйч
- ЗХТ-ийн сургалт хариуцсан ажилтан

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны ᠒4 дугаар сарын ᠒-ны өдрийн
᠕/᠒᠒ дугаар тушаалын ᠒᠑ дугаар хавсралт

᠐᠑2᠐07᠐᠐᠐4
᠑᠐34137-᠕-᠐᠑᠑11714

ГАМШИГ, ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕД АЖИЛЛАХ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН
МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Үйл ажиллагаа	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Нийт
1	Маск	130	380ш	49400
2	Гар ариутгагч	7000	7ш	49000
3	Дархлаа сэргээх бэлдмэл /Сэвитлин/	12000	19ш	228000
4	С витамин	500	38ш	19000
5	Гарын шингэн саван	7000	7ш	49000
6	Чацаргана	34000	5ш	170000
7	Цэнэг ус	4500	4ш	18000
8	Бензин	1540	10л	15400
	Нийт			597800

--- оОо---